

이주여성이 한국생활에서 꼭 알아야 하는 것들

이주여성을 위한 위기대응 노트

以“自己”为重，
并照顾才是最关键。
我是尊贵的！

‘나’를
가장 중요하게 생각하고
돌보는 일이 중요해요.
나는 소중한 사람!

Luôn suy
nghĩ' mình là người
quan trọng nhất và chăm
lo cho chính bản thân mình
là một việc rất cần thiết.
Ta là một con người
quý báu!

«Я»
это самое важное,
а также очень важно
заботиться и думать
о себе.
Я очень важный
человек.



'Би' хамгийн
чухал гэж бодон
өөрийгөө хамгаалах
нь юунаас ч илүү
чухал. Би хамгийн
нандин хүн.



ຂໍ້ມູນສູງສໍາຄັນ!
ສໍາຄັນຫຼືກິດຕາ
ສໍາຄັນກາໃຈທີ່ເພື່ອກາ
ຊະແກ້ໄກເກົ່າ.

"Ako" ang
pinakamahalagang
isipin at ang pangangalaga
sa sarili ay mahalaga.
Ako ay mahalagang
tao!

移居女性危机对应指南手册

Sổ tay hướng dẫn phụ nữ di trú đối phó với những tình huống khẩn cấp

Mga talaan ng pagtugon sa Krisis para sa mga dayuhang kababaihan

Брошюра кризисных ситуаций для женщин мигрантов

សៀវភៅនៃការណែនាំដែលធ្វើឱ្យយស្តាប់ប្រជាពលរដ្ឋនៃក្រសួងរៀបចំសាធារណកម្ម

Цагаач эмэгтэйчүүдийн эгзэтгэй үед
авах арга хэмжээний гарын авлага

이주여성이 한국생활에서 꼭 알아야 하는 것들

이주여성을 위한 위기대응 노트

移居女性危机对应指南手册

Sổ tay hướng dẫn phụ nữ di trú đối phó với những tình huống khẩn cấp

Mga talaan ng pagtugon sa Krisis para sa mga dayuhang kababaihan

Брошюра кризисных ситуаций для женщин мигрантов

សេចក្តីផ្តល់នៅការណែនាំដែលជានំនួយសំរាប់ស្ត្រីអាស្រាប់សំនើ

Цагаач эмэгтэйчүүдийн эгзэгтэй үед
авах арга хэмжээний гарын авлага

이주여성을 위한 위기대응 노트

펴낸 날 2012. 09.

펴낸 이 한국염

원고 초기 한국 생활_**강복정** 가정폭력은 그냥 넘어가면 안 된다_**권미경** 성폭력은 범죄이며, 처벌해야 한다_**정하경주** 성매매는 불법, 성을 사고팔 수 없다_**박수미** 긴급한 상황은 언제나 발생할 수 있다_**이정아**

원고 감수 강성의

번역 중국_김옥순, 리영화 베트남_김수진, 안은경 필리핀_조아나 닥토라죠, 엘사 라구로아르디아 러시아_코발축마리야, 세페로바 나즈미에 캄보디아_김마리아, 천삼남, 윤은정, 초음 찬피련 몽골_메르게드아마르자야, 잔창 봉호자르갈

번역 감수 중국_장리, 동애화 베트남_레티마이투, 응욱 필리핀_조슈아일립 단, 한유진 러시아_무히나마리나, 김옥사나 캄보디아_김수정, 초음 찬피련 몽골_김은경, 출템 어치르 마닥마

삽화 김립

펴낸 곳 한국이주여성인권센터

110-550 서울특별시 종로구 숭인동 178-68번지 4층


Tel_02 3672 8988, 3672 7559

Fax_02 3672 8990

e-mail_wmigrant@naver.com

<http://www.wmigrant.org>

꾸미고 찍음 윤기획 (02 761 8322~4)



©한국염. 2012.

* '이주여성을 위한 위기대응 노트'는 원고, 번역, 감수 과정에서 약간의 차오가 있을 수 있습니다.

* 이 책의 독창적인 내용을 허가 없이 마음대로 전재하거나 복사할 수 없습니다.

이주여성을 위한 위기대응 노트

移居女性危机对应指南手册

Sổ tay hướng dẫn phụ nữ di trú đối phó với những tình huống khẩn cấp

Mga talaan ng pagtugon sa Krisis para sa mga dayuhang kababaihan

Брошюра кризисных ситуаций для женщин мигрантов

ເສັ້ນໄລ້ໃກ່ໄດ້ສຳເນົາຜົນຍັງສຳກັບຄູ່ມະນູນປະເທດສປປ

Цагаач эмэгтэйчүүдийн эгзэгтэй үед авах арга хэмжээний гарын авлага

한글판 | 001

中国语版 | 021

Tiếng Việt Nam | 041

Filipino Edition | 061

Русская версия | 083

ກໍ່ໄດ້ຜົນກາສາຮູ້ | 105

Монгол хэл | 135

Цагаач эмэгтэйчүүдийн эгзэгтэй үед авах арга хэмжээний гарын авлага

Солонгост амьдарч байгаа цагаач
эмэгтэйчүүдийн заавал мэдэх ёстой зүйлс

Монгол хэл

Эхний ярианы сэдэв

Хоёр дахь ярианы сэдэв

Гурав дахь ярианы сэдэв

Дөрөв дэхь ярианы сэдэв

Тав дахь ярианы сэдэв

Анхан шатны солонгос ахуй амьдрал

Гэр бүлийн хүчирхийлэлийг зүгээр
өнгөрөөж болохгүй

Бэлгийн замын хүчирхийлэл нь гэмт
хэрэг бөгөөд шийтгэл хүлээлгэх хэрэгтэй

Биеэ худалдах нь хууль бус бөгөөд,
биийг худалдаж авах буюу зарж болохгүй

Онцгой нөхцөл хэзээ ч гарч бол но

Солонгост амьдарч байгаа цагаач эмэгтэйчүүдийн заавал мэдэх ёстой зүйлс.

Эхний ярианы сэдэв

Анхан шатны солонгос ахуй амьдрал¹⁾

1. Анхан шатны солонгос амьдралын бэрхшээл

Нутгаасаа гарч солонгос иргэнтэй гэр бүл болсон эмэгтэйчүүдэд туулах хүндрэл бол солонгос хэл мэдэхгүйгээс үүссэн хэл ойлголцохгүйн бэрхшээл, солонгосын соёл, ахуй амьдралын хэв маягийн ялгаа, хэл, нийгэм, эдийн засаг сэтгэл санааны шалтгаанаас үүсэх эрх чөлөөгүй байдал зэргээр товчилж болно.

1) Хэл ойлголцохгүйн бэрхшээл: Солонгос хэл сурх газар мэдэх нь.

Гадаадын эмэгтэйчүүд солонгост ирэхийнхээ өмнө мэндлэх арга ба авгайлал, ойр зуурын хэрэглээний угсийг сурч ирсэн бол оршин суух явцадаа ойлголцоу, солонгос хэл сурч зээмшихэд хэрэгтэй байх билээ. Гэвч солонгос хэлийг сайн мэддэггүй ч заавал мэдэх ёстой зүйл бий. Жишээлбэл: Гэр булийнхээ нэрс, өөрийн амьдарч байгаа гэрийн хаяг, солонгос нөхрийн нас болон иргэний үнэмлэхний дугаар зэрэг юм. Энэ бүгдийг мэдэж байж гэрлэлтийн баталгаа, гэр булийн баримтыг оршин суугчийн төвөөсөө авч чадна.

* Солонгос хэл заадаг газар: Орон нутаг бүрийн гадаад гэр бүлд туслах төв, гадаадын иргэдэд туслах төрийн бус байгууллага
“танури дуудлагын төв 1577-5432”

2) Соёл, ахуй амьдралын бэрхшээл:

Ёс заншилыг ойлгох, зөрүү, ялгааг нь зөвшөөрөх хэрэгтэй.

Солонгос амьдралд хэцүү зүйлийн нэг нь хоолны асуудал байдаг. Далайн бүтээгдэхүүн харж байгаагүй гадаадын гэр булийнхэн далайн эргийн нутагт амьдрах болвол амьд загастай хоолыг хараад айж цочих, нутагтаа байнга идэж байсан жимс болон махан хоол нь айл ерхийн орлого болон хоолны соёл түүхээс шалтгаалан худалдан авах боломж нь өөр өөр байж болно. Үүнээс гадна солонгос хоолыг өдрийн гурван удаа бэлдэх, хоол идэх, мен будаа, шел, янз янзын ногоонууд болон төрөл бүрийн төвөгтэй ширээ засалт, хоол хадгалах болон бэлтгэх ялгаа, хоолны ёс дэглэм зэргээс маш их зөрчилдөөн үүсдэгийг ярьдаг. Мөн өөр гэр бүлтэй цуг амьдрах тохиолдолд тэднээс хүсэх шаардлага их байдаг тул бур их хэцүү байдаг байна. Ёс заншил ялгаатай гэр бүл хамт амьдрахын тулд бие биенээс ойлгох цаг хугацаа, тэвчээр шаардагдана.

3) Ганцаараа хийж чадах зүйл тийм ч олон биш.

Гадаад эмэгтэйчүүд нутгаасаа хол ирсэн учраас интернэт болон, утсаар ярихдаа үнэ төлбөр нь ямар байх, хэрэглэх арга зэргийг мэдэх хэрэгтэй. Мөн солонгос гэр булийнхээ амьдралын болопцоо ямарыг нь мэдэж, оршин суугаа газрынхаа ойр хавьд туслаццаа авч болох тусламжын газар бас юу байгаа зэргийг судалж мэдэх хэрэгтэй. Зам тээврийн хөдөлгөөнийг ашиглах арга, барaa худалдан авахын тулд мөнгөний үнэ цэнэ мэдэх, гадаад иргэдийг бүртгэх төв, оршин суугчийн төв зэргийг хаана байдгийг мэдэх хэрэгтэй. Яаралтай уед бусдын тусламжыг авах болон тусламж аваахдаа хэрэгтэй зүйлээ тэмдэглэх нь тохиромжтой.

1) Ганг Буг Жон. Солонгосын эрүүл мэнд гэр булийг дэмжих төв, нийт олон соёлт гэр булийг дэмжих төвийн зохион байгуулагч

2. Гадаадын иргэдийн заавал мэдэх зүйл

1) Гадаад паспорт хадгалах болон гадаадын иргэний үнэмлэх аваадаа

Солонгост орж ирсэнийхээ дараа гадаадын иргэд нь паспортаа байнга биедээ авч явах, гэр бүл болсон гадаадын иргэд нь амьдардаг дүүргийнхээ “гадаад иргэдийг бүртгэх төв” өөс зохион байгууллагдаг “аз жаргалтай эхлэлт” сургалтанд оролцож гадаадын иргэний үнэмлэхээ гаргах хүсэлтээ өгнө. Урьдчилан утсаар лавлаж, хэрэгтэй бичиг баримтаяа бүрдүүлээд очвол тохиромжтой. (www.hikorea.go.kr)

2) Оршин суух эрх, оршин суух хугацаа болон оршин суух зөвшөөрөл сунгах

Солонгос улсын хилээр нэвтрэн орсон гадаадын иргэд ирсэн ангилалдаа тохирох гадаадын иргэний үнэмлэхээ авна. Ихэвчлэн оршин суух хугацаа 1-3жилээр олгогдоно. Солонгос иргэнтэй гэр бүл бологчдод F-6 виз олгогдоно. Гадаад иргэний үнэмлэхийн хугацаа дуусахас 2 сарын өмнөөс оршин суух хугацаагаа сунгуулах хэрэгтэй. Оршин суух хугацаа дууссан тохиолдолд солонгост амьдрах эрх хүчингүй болох тул анхаарах хэрэгтэй.

3) Байнга оршин суух эрх ба Солонгос улсын харьяатын бүртгэл

Солонгост оршин суугаа гадаадын иргэдийн хувьд оршин суух эрхийн ангиллаар оршин суух хугацаандaa амьдрах, гадаад иргэний үнэмлэхийн хугацаа дуусаад иргэн болох эрх ба зөвшөөрөлтэй болвол байнга оршин суух эрх болон Солонгос улсын харьяалал хүсэх өргөдөл гаргаж болно. Жишээлвэл: Солонгос иргэнтэй суусан гадаадын иргэн нь байнга оршин суух эрх болон иргэний үнэмлэх авахад (F-2, F-6) ангиллаар солонгост 2 жилээс дээш хугацаанд амьдарсны дараа солонгос хэлний түвшин тогтоох шалгалаат (2_r шатнаас дээш) өгөх эсвэл нийгмийн нэгдсэн үйл ажиллагаанд оролцсон байх хэрэгтэй. Солонгос хэлний шалгальтын баталгаат худас, санхүүгийн баталгаа, төрсний гэрчилгээ зэргийг нэмж нотариатаар баттуулан шалгальтаар орсны эцэст байнга оршин суух эрх болон иргэний үнэмлэх авах болно. Систем нь байнга өөрчлөгджэх байдаг тул анхааралтай шалгаж байх хэрэгтэй бөгөөд нөхрийн баталгаат бичиг баримт шаардлагагүй болно.

3. Хувийн амьдрал болон эдийн засгийн

талаар хэрэгтэй зүйлс

1) Солонгос улсын барааны үнэ, эдийн засагт хэрэгтэй зүйлс.

Солонгост амьдарч буй гадаадын иргэдийн оршин суух зөвшөөрлийн ангиллыг дагаад ажил амьдралын хүрээ хязгаар шийдэгдэнэ. Солонгос иргэнтэй гэр бүл бологч нар (F-2, F-6) нь солонгос улсын иргэнтэй адил чөлөөтэй ажиллаж болно. Харин ажил хийхдээ ажлын шаардлага (ажлын газар, цагийн хувир, хариуцсан ажил) зэргийг судлан мэдэж, гэр бүлийнхэнтэйгээ зөвшшилцөн шийдэх хэрэгтэй. Ялангуяа анкет болон таницуулга зэргийг бичих, тэгсэлтийн гэрчилгээ хэрэгтэй болно. Солонгос улсын сургууль боловсрол нь бага сургууль (бхил), дунд сургууль (Зжил), ахлах сургууль (Зжил), их сургууль (2-4жил) гэж ангилана. Улс бүр сургалтын ангилал өөр өөр байдаг учраас өөрийнхөө улсын элчин сайдын яаман дээр очиж өөрийнхөө үнэмлэхийн зэргийг баталсан баримт бичиг авч баталгаажуулах хэрэгтэй. Орон нутагтаа ч сурхын тулд сургалтын үнэмлэх хэрэгтэй. Ажил хийхийн тулд Ажил олгох төв, Гадаадын гэр бүлд ажил олгох төв, Ажилд ороход зөвлөх төв зэрэг байгууллагуудад хандах хэрэгтэй.

2) Эрүүл мэндийн даатгалд хэрхэн хамрагдах талаар.

Гадаадын иргэд солонгост амьдрах хугацаандaa эрүүл мэнд муудах тохиолдол их байдаг учраас Иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдах хэрэгтэй. Иргэний эрүүл мэндийн даатгал нь солонгост орж ирээд 3 сараас дээш хугацаагаар оршин суугч эсвэл гадаадын иргэн боловч сургалтаар ирсэн иргэн, ажлын шугмаар ирсэн иргэн, солонгос иргэнтэй суусан

годаадын иргэн зэрэг шалтгаанаар цаашдаа 3 сараас дээш хугацаагаар амьдрах нь тодорхой бол орж ирсэн өдрөөсөө шуд бүртгүүлж болно. Солонгост гэр бүл болсон бол гэр бүл гэдгээрээ бүртгүүлж болно. Иргэний эрүүл мэндийн даатгал нь солонгост ажилд орвол бүртгүүлж болох боловч улс хоорондын харилцан холбооноос шалтгаалж улс орон бурийн төлбөр өөр байна. Ажил эрхлэлтийн даатгал, үйлдвэрийн ослын даатгал болон нийгмийн даатгалд ажил үйлдвэр эрхлэгчид бүртгүүлэх боломжтой.

* иргэдийн эрүүл мэндийн даатгалын төвийн сайт: www.nhic.or.kr

3) Хадгаламжийн дэвтэр ба гар утас нээлгэх боломжтой .

Гадаад иргэд тус улсад мөнгөн хадгаламжийн данс нээлгэхэд гадаад паспорт, гадаадын иргэний үнэмлэхээ бүрдүүлэн очиж банкинд дансны дэвтэр нээлгэх боломжтой. Интэрнет банкны данс нээлгэвэл хялбар дэхэм байх болно. Харин даатгал нь баталгаатай эсэхийг сайн шалгаж үзээд гадаадын иргэний хувьд ялгаварлан үзэх асуудал байгаа эсэхийг судлан зөвлөж гэрээ хийх хэрэгтэй. Ялангуяа эрүүл мэндтэй холбоотой даатгалын хувьд тус улсад төрөөгүй учир урьдчилан сэргийлэх тариа, цусны шинжилгээ өгсний дараа бүртгүүлэх нь цаашдын серэг нөлөөнөөс хамгаалах болно. Гар утас авахадаа гадаадын иргэний үнэмлэх болон 6 сараас дээш хугацаанд байна гэсэн баталгаат хуудас, дансны дэвтэр байвал өөрийн нэр дээр авах эрхтэй. Ялангуяа өөр хүний нэр дээр утас авах тохиолдолд болгоомжтой хандах хэрэгтэй. Бичиг баримтая алдах, гар утасаас гээх зэрэг асуудал үүсэхэд тодорхой арга хэмжээ авч чадахгүйгээс болж чирэгдэл үүсдэг.



Солонгосын барааны унэ, боловсрол, ажилд орох нөхцөл нь ямар бол?
Нийгмийн даатгалд хамрагдах нь ямар бол?
Хадгаламж болон утас наэлгэх бол?
Тэмдэглэл хөтлөх хэвшилтэй болцуоё.

★ Мэдэж байх ёстой зүйлс / давтлага

1. Мэдээллийг тэмдэглэж байх зуршилтай болох

Гэрийн хаяг

Гэр бүлийнхний нэр, төрсөн он, сар өдөр

Гэр бүлийнхнийхээ утас

2. Гадаад иргэдэд зориулсан үйлчлэх төвийг мэдэх, олох

Гадаадын иргэний харьяллын төв, утас

Иргэний оршин суугчийн төв болон эрүүлийг хамгаалах төв, эмнэлэгийг хайж олох арга

Цагдаагийн байгууллага

3. Орчуулгын газрын үйлчилгээний утас

Гадаад иргэдэд үйлчлэх ерөнхий төвийн дугаар: 1345

тануридуудлагын утасны төв: 1577-5432

Гэр бүл болсон гадаадын эмгэгтэйчүүдэд туслах төв: 1577-1366

Солонгост амьдарч байгаа цагаач эмэгтэйчүүдийн заавал мэдэх ёстой зүйлс.

Хоёр дахь ярианы сэдэв

Гэр бүлийн хүчирхийллийг зүгээр өнгөрөөж болохгүй²⁾

Гэр бүлийн амьдрал нь хүн бүхэнд бодсоноос илүү хүнд хэцүү байдаг. Ялангуяа гэрлэлтийн явц болон бодит амьдралын хоорондын ялгаа маш их зөрөөтэй байдгаас бэрхшээл үүсдэг. Эцэст нь энэ бэрхшээлээс болж зөрчилдөөн үүсч, энэ үед уур уцаар болон дуу нь өндөрсөж, бие биенээ шүүмжлэн, харааж зүхэжд хүрдэг. Түүгээр зогсохгүй эд хогшилоо шидэн, хэтэрсэн тохиолдолд хүчирхийлэлд автах болдог. Ийм үед ямар аргаар өөрийгөө хамгаалан тусламж авах боломжтой вэ?

Нэн түрүүнд сэтгэл санаагаа тайвшируулж одоогийн байдал ямар тувшинд байгааг бодох хэрэгтэй. Солонгост гэр бүлийн хүчирхийллийн үед хуулиар хамгаалал авах боломжтой. Тэгвэл гэр бүлийн хүчирхийлэл нь юу болохыг, би ийм тохиолдолд яж хандах вэ гэдгээ мэддэг байх хэрэгтэй юм.



1. Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь:

Гэр бүлийн гишүүн (хань ижил, эцэг эх, үр хүүхэд, хамт амьдарч буй төрөл садан) хооронд бие, оюун санаа, бэлгийн харьцаа, эд хөрөнгийн хохирол үүсгэх үйлдлийг хэнлэ. Энэ хорвоод “зодуулчихаар үйлдэл” гэж байдаггүй. Ямар ч шалтгаан байсан гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн гэмт хэрэг мөн. Тэвчин өнгөрөөх нь асуудлыг шийдвэрлэхгүй бөгөөд дахин давтагдах учир гэр бүлийн хүчирхийллийг тэр даруй эрс шийдвэрлэн арга хэмжээ авах хэрэгтэй.

2. Гэр бүлийн хүчирхийлэлийн илрэл.

Зөвхөн бие махбодийн хүчирхийлэл бус, сэтгэл санаагаар хүчирхийлэл хийх болон гэр бүлийн гишүүний үүргийг гүйцэтгэх чадаагүй үйлдэл бүхэн гэр бүлийн хүчирхийлэлд хамаарна. Зодох, хүчирхийлэх, эрүүл мэндээр хохироо, хаях, харгислан зовоох, хорж хянах, айлган сүрдүүлэх, доромжлох, албадах, эд зүйлсээс эвдэх г.м. Нарийн мэдэгдэхүүний хэдэн асуудлыг ажиглахад дараахь зүйлс хамаарна.

2) Гвон Ми Гён.Солонгосын эмэгтэйчүүдийн эрхийг дэмжих төв, Цагаач эмэгтэйчүүдэд яаралтай туслах төвийн ахлах зөвлөгөө

- 1) Эд зүйлсээ шидэж эвдэн сүйтгэх ба айлган сурдүүлэх үйлдэл, хүчирхийлэл хэрэглэн шарх сорви гаргах үйлдэл, хорих болон эрх чөлөөг нь хаан боох үйлдэл
- 2) Бүх үйлдлийг цагдах болон хөндлөнгөөс оролцох, төрсөн ах дүүс болон наиз нөхөдтэй хүртэл харицах боломжгүй хорих
- 3) Хэтрүүлсэн үгээр хараах, доромжилж заналхийлэх, зүхэх, доромжилсон үг хэллэгэх хэрэглэх, хамаатан гэр бүлийнхнийг нь үл тоомсорлох үйлдэл
- 4) Гадаад паспорт болон гадаадын иргэний үнэмлэх зэргийг өгөхгүй нуух болон булаах үйлдэл, гадаадын иргэний бүртгэл, түр оршин суух сунгалт, байнгийн оршин суух үнэмлэх болон иргэний харьяалалд бүртгүүлж егөх зэрэг шалтгаанаар мөнгө шаардах зэрэг зүй бус үйлдэл
- 5) Албадан хүчирхийлэх бэлгийн үйлдэл, (зодсоний дараа албадан бэлгийн харьцаанд орох, эд зүйлс болон мэс хэрэглэж албадан бэлгийн харьцаа хийх, хэвийн бус гаж донтой бэлгийн харьцаа г.м)
- 6) Албадан жирэмслэл шаардах, албадан үр хөндүүлэх гэх мэт үзүүлэлтийг Өөрөө шийдэн хандах үйлдэл
- 7) Ажил хийлгэхгүй байх болон албадан ажил хийж мөнгө олохыг шаардах, булаах үйлдэл, амьжиргааны хэрэгцээт мөнгө өгөхгүй байх г.м
- 8) Хоол ундыг нь хорьж, солонгос хэлний сургалтанд хамрагдах боломж өгөхгүй байх, өвдсөн ч эмнэлэг авч явахгүй байх үйлдэл г.м

3. Гэр бүлийн хүчирхийллийн үед авах арга хэмжээ.

1) Өдөр тутмын гэр бүлийн хүчирхийлэлд авах арга хэмжээ

Зүй бус харьцаа эсвэл гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа бол... Хэзээ, ямар үед ийм асуудалд орсноо тэмдэглэж бичих, гар утасныхаа дуу хураагчид бичлэг хийх буюу зураг дарж хадгалах бие махбодийн хохирол авсан тохиолдолд эмнэлэгийн тусламж авах, тус ламж авсан магадлагаа авах гэх мэт нотлох баримт байх хэрэг тэй.

2) Гэр бүлийн хүчирхийллийн мэдүүллэг ба тусламж хүсэх

- ① Цагдаагийн газрын мэдүүлэг нь 112, 119
※ Яаралтай мөчид хэрэглэх энгийн солонгос хэлийг мэдэж байх “туслаарай” “орчуулагч хэрэгтэй байна”.
 - ② Гадаадын гэр бүл болсон эмэгтэйчүүдэд зориулсан утас: 1577-1366, 365хоног 24цаг ярийн боломжтой.
- * Цагдаагийн ажилтан нь “Гэр бүлийн хүчирхийллийн холбогдох тусгай хуулийн дагуу” яаралтай түргэн арга хэмжээ, түр зуурын арга хэмжээ, хохирогчийг хамгаалах, өмгөөлах, хэргийн газар нэвтрэх болон шалгах зэрэг хохирогчийг өмгөөлөн хамгаалж гадаадын гэр бүлийн эмэгтэйчүүдийн хувьд заавал хэлмэрчээр дамжуулан зөвлөгөө өгөх газар болон аюулгүй байдлыг хамгаалах төвтэй холбон хамгийн түрүүнд аюулгүй байдлыг хангана.

3) Цагдаагийн ажилтан болон цагдаагийн газар хайж олох:

Гэр бүлийн хүчирхийлэл болон сүрдүүлсэн тохиолдолд гэрээсээ гарсан үед заавал ойролцоо цагдаагийн газар олж тусламж авах буюу зөвлөгөө авах хүсэлт гарган холбогдох байгууллагатай холбогдоно.

- ① Түргэн тусламжийн арга хэмжээ (Цагдаагийн ажилтандаа бүртгүүлэх)
Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллээр тус газар ирсан цагдаагийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах үүднээс яаралтай арга хэмжээ авна. Хүчирхийллийн үйлдэлд хориг тавих, мөрдөн байцаалт болон зөвлөгөө өгөх газар, хамгаалах газар шилжүүлэх (зөвшөөрсөн тохиолдолд, эмчилгээний газар шилжүүлэх),

эмчилгээний хугацаанд зааварлах, ээлжит арга хэмжээнд бүртгэх боломжтой.

- ② Яаралтай түр арга хэмжээ авах (Хохирогч бүртгэх болон цагдаагийн ажилтны үүрэг).
Гэр бүлийн хүчирхийлэл болсон газар дахин үүсэх түгшүүр болон яаралтай тусламж шаардлагатай цагт шуурхай түр арга хэмжээ авна. Хохирогч болон гэр бүлийн гишүүдийг байрлаж буй өрөөнөөс нь гарган тусгаарлаж, гэр болон ажлаас нь ойролцоо 100м дотор ойртохыг хоригло, гар утас болон мэйл, зэрэг цахилгаан холбоо ашигл ах хориотой арга хэмжээ авна.
- ③ Түр арга хэмжээ (Шалгалтын албан эрх, мөн цагдаагийн ажилтны бүртгэл)
Хохирогч болон гэр бүлийн гишүүдийг байгаа өрөөнөөс нь гаргаж гэр болон гэрийн өйр хавийг тойрон 100м дотор ойртохыг хоригло, гар утас болон мэйл зэрэг цахилгаан холбоо ашиглахыг хориглох арга хэмжээ авах болон, эмчилгээний байгууллага болон сувиллийн газар шилжүүлэх, улсын цагдаагийн ажилтны дэмжлэгээр цагдан хорих газар оруулах (1-Зрхийг зөрчсөн тохиолдолд бүртгэнэ)

4) Хохирогчийг өмгөөлөх заавар

Гэр бүлийн хүчирхийлээр зовж байгаа хохирогч эрүүгийн хөргээр хэрэгтэнд ял шийтгэл өгөхгүйгээр хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүднээс шүүхэд хэндэх (Гэр бүлийн шүүх, орон нутгийн шүүх гм.)-д бүртгүүлж хэрэгтэнг дахин халдахгүй байх хориотой арга хэмжээг авах боломжтой.(11.10.26-аас эхэлж хэрэгжүүлсэн).

- ① Асран хүмүүжүүлэгч болох гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хохирогчийн хүсэлтээр төрлийн холбоог хязгаарлах
② Хамгаалал шаардах хугацаа: 6сар (2сараар хориог сунгах боломжтой (Жилийн дотор)
★ Биелийгээгүй тохиолдолд 2 жилийн дотор хорих ял буюу 20сая төгрөгний торгууль тавих болно.

4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн авч болох тусламж

- 1) Мэргэжлийн зөвлөгөө, эрүүл мэнд, хууль зүй, мөрдөн шалгах дэмжлэг
- 2) Хүчирхийлээр хохирогч түргэн тусламж болон хамгаалалтын байр орон сууцаар хангагдах
- 3) Иргэний бүртгэл мэдээллийг хязгаарлах
- 4) Түр байрлах байрыг нууцлах онцгой хамгаалалтанд авах (ур хүүхдүүдийг нь нууцлан өөр сургууль руу шилжүүлэх дэмжлэг)
- 5) Хохирогчид бие сэтгэлийн болон аюулгүй байдлын үүднээс туслах эмчилгээ, сэтгэл санааг нь хэвийн болгох үүднээс хөтөлбөрт хамруулах.
- 6) Хэрэгтэнг засан хүмүүжүүлэх хөтөлбөрт хамруулж хүчирхийлэл дахин давтажаас сэргийлж сургалтанд хамруулах .

5. Бусад түргэн тусламжийн дэмжлэг.

- 1) Гэмт хэргийн хохирогчид туслах төв 1577-1295
Гэмт хэргийн улмаас амжиргааны байдал хүндэрсэн тохиолдолд хохирогчид тодорхой шаардлагатай тусламж болон эмчилгээний төлбөр, тэтгэмж, сургуулийн төлбөр зэрэг эдийн засгийн дэмжлэг үзүүлэх болон гэмт хэргийг засан хүмүүжүүлэх, зөвлөгөө болон эмнэлэгийн тусламж, шалган байцаах явцад хуулийн дагуу туслах зэргээр үйлчилнэ



2) Түргэн тусламж (хот, дүүрэг, хороо, нийгмийн халамжийн хэлтэс 129)
 Бэртсэн болон хүнд өвчилсөн тохиолдолд, гэр бүлийн гишүүдээс гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн зэрэг шалтгаанаар гэр бүлээ тэжээх чадваргүй тохиолдолд амжиргааны тэтгэлэг болон эрүүл мэндийн зардлаар түр тэтгэх зэрэг тусламж үзүүлнэ.

6. Тусламж авах боломжтой байгууллагууд.

Байгууллагын нэр	Утасны дугаар	Үйл ажиллагааны агууллага
Солонгосын цагаач эмэгтэй чүүдийн эрхийг хамгаалах төв	02-3672-8988	Цагаач эмэгтэйчүүдийн бодлого, төвлөвлөөгээг эх мэт дэвшилттэй үйл ажиллагаа
Цагаач эмэгтэйчүүдэд зөвлөгөөгээг газар 'Ултари'	02-3672-7559	Цагаач эмэгтэйчүүдийн хүний эрх, оршин суух зэрэг зөвлөгөө (Монгол, вьетнам, хятад, орос гэх мэт хэлээр)
Бусаны салбар (Бусаны цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв)	051-864-2603	Зөвлөгөө, сургалт, ажлын байр
Тэгүү салбар (Тэгүүгийн цагаа ч эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв)	053-944-2979	Түр амрах байрны үйл ажиллагаа, зөвлөгөө, сургалт, ажлын байр
Чүнбүгүү салбар (Чүнбүгийн цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв)	043-223-5254	Түр амрах байрны үйл ажиллагаа, зөвлөгөө, сургалт, ажлын байр
Гённнам салбар (Гённнамын цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв)	055-741-6355	Зөвлөгөө, сургалт
Жоннам салбар (Жоннамын цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв)	061-272-1562	Зөвлөгөө, сургалт, ажлын байр
Жонбүгүү салбар (Жонбуягийн цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв)	063-227-2990	Түр амрах байрны үйл ажиллагаа, зөвлөгөө, сургалт,
Солонгос эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллага Солонгос иргэнтэй гэр бүл бологч гадаад эмэгтэйчүүдэд яяралтай тусламж үзүүлэх төв	1577-1366	365хоног 24цаг солонгос хэл болон 10 орны хэлээр зөвлөгөө болон орчуулгын тусламжийн газар Монгол, Орос, Хятад, Ветнам, Таиланд, Англи, Камбудиа, Япон, Узбек, филиппин
Солонгосын эрүүл мэнд гэр бүлийн байгууллага Танүрикул төв	1577-5432	Олон соёлт гэр бүлийнхэнд солонгос амьдралд дасан зохицоход туслах төрөл бүрийн амьдралын хэрэгцээт мэдээ мэдээлэл болон шаардлагатай байгууллагатай холбох, орчуулга тусламж 10 орны хэлээр үйлчлэх

Солонгост амьдарч байгаа цагаач эмэгтэйчүүдийн заавал мэдэх ёстoy зүйлс.

Гурав дахь ярианы сэдэв

Бэлгийн замын хүчирхийлэл нь гэмт хэрэг бөгөөд шийтгэл хүлээлгэх хэрэгтэй.³⁾

‘Бэлгийн замын хүчирхийлэл гэвэл хамгийн түрүүнд юу бодогдох вэ?’ гэж асуухад зарим хүмүүст шенийн харанхуй гудамжинд танихгүй хүний хүчирхийлэлд өртөх бодогдж байхад зарим хүмүүст нь ажлын газрын дээд тушаалтны түрэмгий дургуй хүргэсэн ааш, уг, үйлдэл санагдаг байна. Бас бүдүүгээ муу үйлдэл, надад хамаагүй хэрэг гэж бодох хүн ч байдаг байна. Гэвч бэлгийн замын хүчирхийлэл нь хэнд ч тохиолдож болох зүйл юм. Яг бэлгийн хүчирхийлэлд өртөх юм бол өөрийнх нь буруу биш байтал ичих болон гэмших сэтгэл тэрснээс болоод ойр дотны хүмүүсдээ хэлж тусламж авч чадахгүй буруудах явдал байдаг байна.

1. Бэлгийн замын хүчирхийлэл гэдэг нь

Бэлгийн замын хүчирхийлэл гэдэг нь хувь хүний сэтгэл алдагдса наас үүссэн хүчирхийлэл болон ёс бус үйлдэл, хүйсээр тохуурхах гэх мэт хүйсээр дамжигдан хүчирхийлэл явагдах бух л бие эрхтэн, сэтгэл санааны хүчирхийлэл болон хүний эрхэнд халдсан үйлдлийг хэлнэ. 1994 онд солонгост бэлгийн замын тусгай хуулийг бий болгосон бөгөөд ‘Өөрөө шийдэх бэлгийн эрх чөлөөнд халдах’ нь гэмт хэрэг учраас бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол шийтгэл оногдуулах болсон байна. Сүүлийн үед бэлгийн хүчирхийллийг ‘зөвшөөрөөгүй бэлгийн ха ръцаа’ эсвэл ‘Өөрөө шийдэх бэлгийн эрх чөлөөнд халдах’ тухай гэмт хэрэг гэдгэр шийдвэрлэхээр нийгмийн зөвшилцэл улам бурдаж бай гаа боловч урьдын адил нийгэм дэх тэгш бус харьцаанаас үүдэн бэлгийн хүчирхийлэл их гарах нь хэвээр байна.

Жишиэгблэг: Албан газрын нийт ажилчдын хоолпоо үед эрэгтэй дээд тушаалтан доод тушаалтын эмэгтэйг хажуудаа суулгаж архи аягалахыг шаардахад, ажиллах явцад шууд нөлөөлөх чадварыг хэрэгжүүлж болох дээд тушаалтанд татгалзсан үйлдэл үзүүлэх нь хэцүү байж болох шалтгаан юм. Тийм болохоор бэлгийн замын хүчирхийллийг шийдэх хэмжүүр нь хохирогчийн зөвшөөрөх асуудал Тийм эсвэл Үгүй гэсэн зөвхөн хоёр үргийн сонголтоос шалтгаалах биш хохироогч өөрөө сонголт хийн шийдэх үйлдэл бас хэрэгтэй юм.

2. Бэлгийн замын хүчирхийллийн байдал:

Бэлгийн замын хүчирхийлэл нь бэлгийн замын хүчирхийллийн үйлдэл-хохироогчтой ямар холбоотой - бэлгийн замын хүчирхийлэл болсон орон зайд зэргийг дагалдан маш олон төрлийн хэлбэрээр гардаг.

1) Үйлдлээс шалтгаалан ангилал:

- ① Бие эрхтэний бэлгийн замын хүчирхийлэл: Хүсээгүй бэлгийн ха ръцаа, бэлгийн ёс бус үйлдэл, хүчирхийлэл зэрэг хүчээр бие эрхтэн нийлэх г. м

3) Чон Ха Гён Жу (당당한 성 · 안전한 성 · 즐거운 성) Солонгос эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн үйлдэлээ мыйн хүчирхийллийн зөвлөгөөө өгөх төв



② Харах мэдрэхүйн бэлгийн замын хүчирхийлэл: Биеийг эрээ цээрүүг харах үйлдэл, садар самуун зүйл хүчээр харуулах юмуу олон нийтийн газар харах үйлдэл, түүнээс гадна нээлттэй орон зайд бэлэг эрхтнээ ил гаргах буюу оролдох үйлдлэл гэх мэт шууд бие эрхтэн нийлээгүй ч гэсэн харах мэдрэхүйгээр эвгүй сэтгэл болон гутамшигтай сэтгэл болон төрүүлсэн үйлдэл.

③ Хэл ярианы бэлгийн замын хүчирхийлэл: Садар самуун яриа болон бие, өнгө зүсний талаар үнэлэх, үгээр дамжуулан бэлгийн замын эвгүй болон гутамшигтай сэтгэгдэл төрүүлэх үйлдэл.

2) Харьцаанаас шалтгаалан ангилас:

- ① Танилын харьцаанаас үүсэх бэлгийн замын хүчирхийлэл
- ② Болзооны явцад үүсэх бэлгийн замын хүчирхийлэл
- ③ Хамаатан садны харьцаанаас үүсэх бэлгийн замын хүчирхийлэл

3) Орон зайнаас шалтгаалан ангилас:

Гэр - сургууль - албан газар - олон нийтийн газар гэх мэт хаана ч бэлгийн замын хүчирхийлэл гарч болно. Бас суулуйн үед компьютэрээр зайнаас үүсэх бэлгийн замын хүчирхийлэл ч нэмэгдэж байна. Үүгээр зогсохгүй интэрнетээр зайнаас дамжуулсан уулзалтас үүдсэн бэл гийн замын хүчирхийлэл ч гарсан тохиолдол байна. / Нийт орон нутгын цагдан сэргийлэх газар мөрдөн байцаах төв/ Сургууль болон албан газар дотроос бэлгийн замын хүчирхийлэл гарсан тохиолдолд хо хирлын талаар хэнд хэлж тусламж авахаа мэдэхгүй бас хэлж чадахгүй хохирогч ажил болон сургуулиасаа гарах тохиолдол ч байна. Метро бо лон олон нийтийн газар хохиролд өртөх юм бол хашигран ойр орчмынхао хүмүүсээс тусламж хүсэх буюу метроны буудлын ажилтан болон метроны мөрдөн байцаах газар мэдэгдэх хэрэгтэй.

3. Бэлгийн замын хүчирхийлэлд өртсөн үед авах хариу арга хэмжээ

1) 'Би' өөрийгөө хамгаалах.

Бэлгийн замын хүчирхийлэл гарах үед хамгийн түрүүн хийх ёстой зүйл бол 'Би' хамгийн чухал гэдгийг бодоод өөрийгөө хамгаалах яв дал юм. Тэгээд сэтгэлийн шархаа эдгээхийн тулд сэтгэхүйн болон бусад курс эмчилгээнд хамрагдах хэрэгтэй.

① 'Надад буруу байгаа юм болов уу' гэсэн бодлоо орхих.

Би азгүй хүн учраас эсвэл ямар нэгэн буруу юм хийснээс бэлгийн замын хүчирхийлэлд өртөж байгаа юм болов уу... Ямар ч гэмт хэргийн хохирогчдод хариуцлага оногдох гэмт хэрэг байхгүй. Яалт ч угүй хохирогчийн хийсэн үйлдэл бөгөөд шийтгэл хүлээх хүн нь хохироогч гэдгийг ямаргүй санаж явах хэрэгтэй.

② Өөрийнхөө мэдэрсэн аймшиг болон арга барагдсан мэдрэмжийг хү лээн зөвшөөрөх.

Тухайн үед мэдэрсэн аймшиг, арга барагдсан мэдрэмж зэргээс болж гутрах юмуу эргэж хуучин байдалдаа орж чадахгүй өөрийгөө зовоох нь ч бий. Гэмт хэрэг гарах үед хохироогчид эсэргүйцэл үзүүлж чадаагүйгээ 'Би арчаагүй, эрч хүчгүй учраас' биш хэн ч гэсэн тийм байдалд сүйхээгүй болчихдог гэх бодох хэрэгтэй.

③ Өөрийнхөө уур хилэнг хүлээн зөвшөөрөх.

Хохироогчийн үйлдлийн талаар уур хүрэх нь мэдээж хэрэг. Ийм сэтгэлийн хөдөлгөөн нь тухайн хэрэг болж байх явцад ч гарч болох ба бүр сүүлд тодорхой цаг хугацаа өнгөрсний дараа ч илэрч болох юм. Уур хилэнгээ гаргах хүч чадал байнаа гэдэг нь өөрийгөө чухал гэж бодох нэр төрөө эрхэмлэх сэтгэл байнаа гэдгийг тодорхойлж өгч байгаа сөрөг нотолгоо юм.

④ **Өөртөө хэрэгтэй зүйлийг хайх.**

Одоогийн нөхцөл байдалд миний хүсэж байгаа юм ю билээ, хохирлын талаар яаж ямар арга хэмжээ авч болох нуу гэдэг талаар зөвлөгөө авах юм уу хуулийн шат дамжлага гэх мэт асуудлаар судалж сурч мэд дэх хэрэгтэй. Гэмт хэргийн талаар тэмдэглэл бичих нь түүгээрээ дамжуулан гэмт хэргийн аюулыг тодорхойлох шүүхийн шийдвэрийг ч хурдасгаж болох сайн талтай. Өөртөө тохиолдсон хэргийг амьдралд тохиолдох л зүйл гэж бодон хамгийн гол нь амьдрах эрч хүчийг бий болгоход тус болж болох юм.

⑤ **Өөрийгөө дэмждэг, дуртай хүмүүстэйгээ цагийг хамт өнгөрүүлэх.**

Бэлгийн замын хүчирхийллийн хохирогчийг эмчилж эдгээх болон хэвийн байдалд нь оруулахад чиглэгдсэн цуглаан болон бүлгийн чанартай хөтөлбөрт оролцож ч болох юм. Хөтөлбөрт оролцонгоо өөртөөгөө адил тестэй хохирогч болсон хүмүүстэй уулзан хохирлын талаар ярил цах явицдаа өөрийнхөө талаар ярьж ч болох юм. Хэн нэгэнд ярих нь амаргүй хэцүү зүйл боловч мартаж эдгэрэхийн эхлэл болох талтай.

2) Хохироогчид хариу арга хэмжээ авах.

① **Бэлгийн замын хүчирхийлэл нь гэмт хэрэг гэдгийг ойлгуулах.**

Зөвхөн хохироогчид ч биш хохирогчид ч мөн бэлгийн замын хүчирхийлэл гэдэг ухагдахууныг мэдэрч байгаа тохиолдол их байгаа учраас бэлгийн замын хүчирхийллийг хохирогчийн хариуцлагаруу эргүүлэх юм бол хохирогч өөрийнхөө хохирлыг ойлгуулж чадахгүйн улмаас тохирсон хариу арга хэмжээ авч чадахгүйд хүрэх тохиолдол ч байна. Танидаг хүн бэлгийн ёс бус хүчирхийлэл үйлдэхэд энэ бол бэлгийн замын хүчирхийлэл гэмт хэрэг гэдэг талаар хоромхон зуур төөрөгдэж, эргэлзэж ч болох юм. Байгаа бэлгийн замын хүчирхийллийн ухагдахууны талаар тодорхой мэдлэгтэй байж хэрэг гарах уед хариу арга хэм жээ авч чадах эрч хүчийг агуулж байх хэрэгтэй.

② **Хохироогчид хэлэх.**

Хохироогчид бэлгийн замын хүчирхийлээр бусдад хохирол учруулсан тухай асуудал тавих нь амар биш байж болох юм. Хохироогчийг хараад тавгүйтэх болон айк эмээж болох учир эргэн тойрны хүмүүс (өөрийн болон хохироогчийн эргэн тойрон) ын туслацааг авах, мөн нөхцөл байдлаа албаалаад асуудлыг шийдэхийн төлөө мэргэжсэн бэлгийн замын хүчирхийллийн зөвлөгөө өгөх төвийн төлөөллөөр дамжуулан хэлж болох юм. Хохирогчтой шууд тулж уулзан асуудал дэвшүүлэх нь маш хэцүү гэх юм бол гар утасаар мессаж явуулах болон майл, захия илгээх гэх мэтээр дамжуулан мэдэгдэж болно.

③ **Хүчирхийллийн талаархи нотлох баримтыг цуглуулах.**

Хээээ, хаана, яаж хүчирхийлэлд өртсөн талаар тодорхой тэмдэглэл хөтлөн, нотлох баримтуудаа цуглуулах нь хамгийн чухал. Даруй хохироогчийг хуулийн дагуу шийтгүүлэх бодолгүй ч гэсэн сүүлд сэтгэл санаа өөрчлөгджэх ч болох юм. Бэлгийн замын хүчирхийллийн гэмт хэрэг нь гэмт хэрэгтнийг мэднээс хойш нэг жилийн дотор бол хээээ ч хамаагүй зарга үүсгэж болно. Нотлох баримтыг цуглуулах нь зарга үүсгэхгүй ч гэсэн хохироогч бултах болон хохирогчтой холбоотой балмад зүй бус ааш авир гаргахаас сэргийлэх ач холбогдол ч болно.

* **Бие эрхтнээ угаалгүй (угаасан ч) заавал эмнэлэг явах.**

Бэлгийн замын хүчирхийлэлд өртсөний дараа бие эрхтнээ угаал гүй эмнэлэг (эмэгтэйчүүдийн эмнэлэг) т очоод хохирлын нөхцөл байдлын талаар эмнэлэгийн магадлагаа болон шинэжилгээ хийлгэх хэрэгтэй. Хохирлын байдлаас шалтгаалан шархтай хэсгийг эмчлүү лэн хохироогчийн үрийн шингэн болон бэлэг эрхтнэй үс гэх мэт нотлох баримт олж авах ба бэлгийн замын халдварт өвчин туссан эсэх шинжилгээ, жирэмсэн болсон эсэх шинжилгээ болон яаралтай жирэмснээс сэргийлэх эмийн жор авах хэрэгтэй. Түүнчлэн сэргий лэх,

원스탑 төв, бэлгийн замын хүчирхийллийн зөвлөгөө өгөх төв зэрэг газруудын тусlamжийг авах нь сайн.

- * Хохирлын үед өмссөж байсан хувцас зэрэг нотлох баримтыг цаасан утанд хадгалах.

Хүчирхийлэлд өртсөн тухайн үед хувцасанд наалдсан үрийн шингэн болон бэлэг эрхтэний үс, биеэс гарсан шингэн бодис зэрэг нь нотлох баримт болох учраас эдгээрийг цаасан утанд хийж хадгалах хэрэгтэй. Гялгар уут болон бүрмэл цаасан уут нь агаар орохгүй учраас нотлох бодис илжирч муудах зэргийг харгалзан заавал цаасан утанд хийж тавих нь нотолгоо хадгалж хамгаалахад аюулгүй юм.

- ④ Хууль журмыг дагах.

Бэлгийн замын хүчирхийллийн хохирогч хэн бүхэн төлбөргүй хууль зүйн тусlamж авах боломжтой. Эрүүгийн хэргийн зарга гэх мэт шүүхэд заргалах явцад үнэгүй тусlamж аван өргөдөл гаргахдаа тус орон нутгийн зөвлөгөө өгөх төв, бүгд найрамдах солонгос улсын хууль зүйн туслалцаа өгөх газар, бүгд найрамдах солонгос улсын өмгөөлөгч дийн холбоо гэх мэт газруудад хандан зөвлөгөө болон хууль зүйн туслалцаа авч болно.

3) Эргэн тойрноос хийх хэрэгтэй зүйл.

- ① Хохирогчтой адилхан бодолтой байх.
- ② Хохироогч өөрөө бэлгийн замын хүчирхийлэл нь гэмт хэрэг гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх.
- ③ Хохирогчийг мэдээлэх (Сэргийлэхэд мэдээлэх 112, 1366, 1577-1366)
- ④ Хохирлын уршгийг давж гарах
- ⑤ Хохирогчтой хамт мэргэжлийн хүний тусlamжтайгаар сэтгэхүйн эрүүл мэндийг нь хамгаалах

★ Эмнэлэгийн магадлагаа болон гэмтэж бэртсэн хэсгийн зургийг авч улдэх: Хохирлын дараа даруй авна. Хавдар нь 2-3 хоногийн дараа илүү тодорч болох юм.

★ Нотлох баримтыг хадгалах: Тухайн үед өмссөж байсан хувцас, үс, хумс зэргийг хадгалана. Тухайн хэрэг гарсан газар хохироогчийн биеийн хэсэг болох ул мөр, үс, бэлэг эрхтэний үс, үрийн шингэн, хэлс зэрэг улдсэн байж болзошгүй учраас хадгалах боломжтой бол хадгалах нь сайн.

★ Хохироогч нь танихгүй хүн юмуу танидаг хүн байсан ч хүчирхийллийг угүйсэж болох талтай тул урьдчилан сэргийлж хохироогчийн онцлог, хохироогч той холбоотой санаанд орсон бүх зүйлээ нэг бүрчлан бичиж үлдээнэ.

★ Гэмт хэргийг тэмдгэлж үлдээх: Тодорхой газар, цаг, он сар өдөр, гэрч, өөрийн хариу арга хэмжээ, хохироогчийн бие авч яваа байдал болон үйл хөдлөл зэргийг тодорхой тэмдэглэх үлдээнэ.

★ Бэлгийн замын хүчирхийллийн улмаас үүссэн магадлагаа, шинжилгээ, түүний дараах хор уршиг, эмчилгээ зэрэгт улсаас тусlamж авч болно. Эмчилгээ, хууль зүйтэй холбоотой тусlamж мэдээллийг тус бус нутгийн бэлгийн замын хүчирхийллийн зөвлөгөө өгөх төв юм уу цагдан сэргийлэх газар, бүгд найрамдах солонгос улсын хууль зүйн туслалцаа өгөх газар (улсын дугаар байхгүй 132) зэргээс авч болно.



Солонгост амьдарч байгаа цагаач эмэгтэйчүүдийн заавал мэдэх ёстой зүйлс.

Дөрөв дэхь ярианы сэдэв

Биеэ худалдах нь хууль бус бөгөөд, биеийг худалдаж авах буюу зарж болохгүй⁴⁾



Солонгосын хууль журмаар бол бие худалдах үйдэл нь хориотой. Биеийг худалдах үйлдлийн гол болсон 'Завхайрах', 'Бие үнэлэх' гэсэн нэр томъёо нь бие үнэлэгч эмэгтэйчүүдийг хохирогч гэж хүлээн зөв шөөрөх юм уу хамгаалах, туслах хэрэгтэй гэдэг ойлголт төрүүлж чадахгүйд хүргэж байсан бөгөөд үүнээс үүдэн 2004 онд бие үнэлэхээс сэргийлэх хуулийг бий болгосон байна. Хүйсийг тойрсон бие худалдах гэх мэт бараа бүтээгдэхүүн нийлүүлэх бүх үйлдлүүдийг гэмт хэрэг гэж үзнэ гэсэн байр сууриар бие үнэлэгч гэх хохирогчдыг хамгаа лан туслацаагаа гэсэн агуулгыг багтаасан байна. Солонгосын хуулинд 'Бие үнэлэх' болон 'Бие үнэлэх үйлдэлийн хохирол'ыг дараах байдлаар тодорхойлон ялангуяа гадаад иргэний хувьд бие үнэлэх зорилготой хүний наймааны хохирлыг хамтатгаж байгаа тохиолдолч байна. Бие үнэлэхээс сэргийлэх хуулинд тогтоосноор 'Бие үнэлэх болон хүний наймааны' талаар юу гэж тусгасныг үзэцгэе.

1. 'Бие үнэлэх', Бие үнэлэх үйлдлийн хохирогч, Бие үнэлэх зорилготой хүний наймааны бодит байдал.

1) Бие үнэлэх гэдэг нь:

Энгийн иргэдийг ашиглан алттан эдлэл түүнээс гадна хөрөнгөө ёсгэж ашиг олох зорилгоор, мөн хүлээн авсны дараа дараах эүйлүүдийн аль нэгт дүйцэх үйлдэл юмуу харилцагч тал болохыг хэлж байгаа юм.

- ① Бэлгийн харьцааны үйлдэл
- ② Амны хөндий, шулуун гэдэсний амсар гэх мэт биеийн нэг хэсэг болон мөн багаж хэрэглэсэн бэлгийн харьцаатай төстэй үйлдэл

4) Bak Su Mi '두레방' гадаад иргэдэд туслах байгууллагын дарга

2) 'Бие үнэлэх үйлдлийн хохирогчийн байдал'

- ① Хүчирхийлэх буюу сурдгуулэн биеийг нь үнэлүүлэх хүчинд өртөгч
- ② Албан ажил болон удирдлагын хүчин дор мансуурах бодисонд хор дон бие үнэлэх үйлдлээр хохирогч
- ③ Насанд хүрээгүй юмуу сэтгэл санаагаа илэрхийлэх сэтгэцийн чад вар муу хүн, биеэ хамгаалах чадваргүй тахир дутуу хүн
- ④ Бие үнэлэх зорилготой хүний наймаанд өртөгч

3) 'Бие үнэлэх зорилготой хүний найма'

- ① Бие худалдах үйлдэл нь эргүүгийн хуулийн 245р зүйлд тогтоосноор садар самуун үйлдэлийг хэлэх буюу бэлгийн харьцааны үйлдэл гэх мэт садар самуун агуулгыг багтаасан зураг, дурс бичлэх гэх мэт бичлэгийн объектын зорилгоор эрх дарх, сүр хүч зэрэг аргаар объектыг захи ран тушааж 3 дахь этгээдэд дамжуулан егсэн үйлдэл
- ② Нэгдүгээр зүйлд заасантай төстэй зорилгоор ёсвөр насынхыг хамгаалах хуулийн 2р зүйл ангийн 1д зааснаар (доор 'ёсвөр нас' гэнэ), хэрэг явдал эд зүйлийг ялан салгах болон шийдвэр гаргах чадваргүй юмуу сүл дорийг этгээд мөн ерөнхийлэгчийн зарилгаар дунд болон дээр зэр гийн тахир дутуу иргэн буюу түүнийг асран хамгаалагчид урьдчилсан төлбөрийн мөнгө түүнчлэн үнэт эдлэл, эд хөрөнгө ёсгөх ашиг орлого нийлүүлэх, тохиолцсоор объектыг захираан тушаангагаа 3 дахь этгээдэд дамжуулан егсэн үйлдэл
- ③ Тайчих гэх мэт нүцгэлэх үйлдэл үйлдэгдэж байгааг мэдсэн хир нээ тайчих зорилго болон монополь худалдааны төлөө объектыг дамжуулан авах үйлдэл
- ④ Тайчих эсвэл олон талын зориулалтаар объектыг шалгаруулж авах, шилжүүлэх, нуун дарагдуулах үйлдэл.
Дээрхи шудрага бус үйлдэл болон хохирогч нь ёсвөр насынхыг бие болон сэтгэлээр сүл дорийг этгээд тайчих арга, тухайн суурин дээр суух хүч чадал байхгүй ч гэсэн хохирогчийн асран хамгаалагчид ашиг орлого нийлүүлэх тохиолдолд ч хүний наймаа явагдаж байгаа юм. Мөн хохирогчийг зөвхөн захираан тушаах үйлдлээр дамжуулан хүлээн авах үйлдэл ч биш сонгон шалгаруулах, шилжүүлэх, нуун дарагдуулсан үйлдлийг ч бас хүний наймаанд тооцно.
Ялангуяа энэ хууль нь зөвхөн урьдчилсан төлбөрийн мөнгө ч биш гадаадын иргэдийн хувьд паспорт гэх мэт аялалын бичиг баримтыг нь хураах явдал нь бас хүний наймааны зорилготой арга гэж заасан. Яагаад гэвэл паспортыг нь хураах гэдгээр объектыг бие худалдах наймаанаа тусгаарлан тайлбарлаж болох учраас юм. Түүнчлэн объектын талаар захираан тушаах үйлдэл болсон гэж үзэж болох талтай.⁵⁾

2. Ажил хийх цаг, мэргэжлийн онцлог, анхаарах зүйл

- 1) Зугаа цэнгэлийн салбар: Солонгос нь зугаа цэнгэлийн газар тайчих ажил эрхлэхийг зөвшөөрдөг. Гэвч бүртгэл, журам байхгүй хирнээ ажиллах тохиолдолд хариуцлагыг хөлслэгч төдийгүй ажил эрхлэгч өөрөө ч мөн үүрэх болно.
- 2) Караокэ: Караокэд зочдыг зугаацуулахын төлөө туслах ажил хийдэг цагаач эмэгтэйчүүдийн хувьд болгийн ёс бус үйлдэл, бэлгийн хүчирхийлэлд өртөх явдал их байдаг. Ялангуяа ажиллах эрхгүй визтэй тохиолдолд ноцтой хохиролд өртсөн ч гэсэн мэдэгдэх юмуу хуулийн дагуу арга хэмжээ авч чадахгүй байгаа нь үнэн. Гэвч хууль дурмийн дагуу ажил хийх боломжгүй визтэй ч гэсэн бие худалдахтай төстэй бэлгийн

5) 'Дурзбан' Гадаад иргэдийг дэмжих төв. Бие үнэлүүлэх пүүс, компанийд хууртагдан бие үнэлэх үйлдлийн хохирогч болсон гадаад иргээдэд туслахын төлөө хуулийн танилцуулга

харьцааны хохирол амссан тохиолдолд зөвлөгөө өгөх төв болон тусламжийн байгууллагаар дамжуулан хохирлыг мэдэгдэж болох бөгөөд аюулгүй арга хайж идэвхитэй хариу арга хэмжээ авч адилхан хохи рол гаргахгүй байх хэрэгтэй.

3) Массажены салбар: Зөвхөн харах мэдрэхүйн согогтой тахир дутуухүн зэрэг хууль зүйн зөвшөөрөлтэй хүн лэнэ салбарыг эрхэлж болох ба ажиллах эрхтэй. Эрх байхгүй ажил хийж байгаад баригдах юм бол эрхэлж байгаа хүн төдийгүй массаже хийж байсан хүнд ч шийтгэл /торгууль/ ногдоно. Ялангуяа сүүлийн үед байнгийн оршин суух эрх болон иргэншил мэдүүлэх иргэний бүртгэл мэдээллийн хуулинд ч гэсэн дээрхи журмыг биелүүлэгчийг хүн мен 'Эрүүл мэндийн хууль' гэх мэт ерөнхий дотоод хуулийн шийтгэлийн дагуу шийтгэл хүлээнээр хохирол амсч байгаа жишээнүүд нэмэгдсээр байна.

3. Аюулгүй ажилд орох мэдээллийг ялгах арга.

- 1) Хэтэрхий дэвийлгэсэн зарлалаас болгоомжлох хэрэгтэй. Цалинг үнд сэн түвшнээс дээгүүр хэлэх юм бол яалт ч угүй бие үнэлэхтэй хол боотой тохиолдол их байдаг.
- 2) Бие үнэлэх газар нь өөрийн саналд тулгуурлан бие үнэлэх зүйл биш. Тухайн хүн цаашдаа ажиллахыг хүсэхгүй тохиолдолд ч өөрийн дураар тэр газраас гарч явах нь хэцүү.
- 3) Хүчээр гоо сайхны бүтээгдэхүүн болон хувцас гэх мэт бүтээгдэхүүн авах хэрэгтэй болдог бөгөөд өр зээлийг төлүүлэхийн тулд биеэ худалдахыг шаардах тохиолдол ч бий.
- 4) Ажил мэргэжлийн зуучлах алба, ажилд зуучлах байгууллагудын /sate/ зуучласнаар хүний наймааны хохирогч болсон жишээ ч бий. Тиймээс хэт өндөр хураамж шаардсан зуучлах албадаас болгоомжлох хэ рэгтэй.



4. Ажил хайх явц болон ажилд орсны дараа анхаарах ерөнхий зүйл .

- 1) Цалин хэлс болон хөлслегч эзэн жирийн тохиолдолд болж өгвөл бэлэн мөнгө авахаасаа илүү дансаар шилжүүлж авах нь дараа ямар нэгэн асуудал үүссэн нөхцөлд хохирлыг нотлоход тус болно.
- 2) Караокэ, цайны газар, цэngээний газар ажил хийлээ гээд авч чадаагүй ажлын хэлсөө нэхэж чадахгүй тохиолдол их байгаа ба ажил олгогч эзний талаар мэдээлэл байхад л хангаттай бөгөөд хөдөлмөрийн яаманд өргөдөл гаргаснаар авч чадаагүй хөдөлмөрийн хэлсөө авч чадахгүй тусламж авч болно. Бие үнэлэх хэлс болох /Уг хүн хохирогч гэж үзэх юм бол/ хохирлын төлбөрийг нэхэмжлэх гэх мэтийг хуулийн дагуу шийдүүлэх нь тустай.
- 3) Бие үнэлэх зорилгоор ажил олгогч эзэн зориудаар өөртөө өртэй болгосон бол тэр өрийг нь хуулийн журмаар төлөхгүй байсан ч болно.^{⑥)}
- 4) Бүртгэлгүй байсан хохирогч улсын бүртгэл мэдээллийн албаны баривчилгаанд өртөн саатуулагдах байранд хоригдсон тохиолдолд ч сэргийлэхийн шалгалтаар дамжуулан хохирлыг нотлуулан түр зуур чөлөөлөгдөж болно.

6) Бие үнэлэхийг зохицуулсан этгээд, бие үнэлсэн эмэгтэйг ажиллуулсан, шалгаруулсан этгээд, бас бие үнэлэх зорилгоор хүний наймаа хийсэн этгээдийн тухайн үйлдэлтэй холбогдон бие үнэлсэн эмэгтэйг авчирсан ёр зээл, авлагыа нь тэр гэрээний байдал болон хэлбэрээс шалтгаалахгүйгээр хүчингүй болно. Тэр авлагийг зөвхөн шилжүүлэх ч биш өрийг хариуцаж авсан тохиолдолд ч мөн адилхан. Тиймээс танилцуулсан болон хулээн авсан эзэн гэх мэт этгээдүүд төдийгүй эмэгтэйг авчран бие үнэлэх болзонтойгоор урьдчилсан төлбөр, авлагыа үүсгэсэн эзэн урьдчилсан төлбөрийн мөнгө, авлагийг хувийн эзэн олгогчдод шилжүүлэн өгсөн тохиолдолд ч хүчингүй болно.

5. Биеэ үнэлэхийг албадах болон зуучлалын хохирлын үед авах арга хэмжээ.

- 1) Биеэ үнэлэхийг албадсан гэдгийг нотлох маш хэцүү боловч үйл яв далын өмнө гадны нөлөөтэй хүчирхийлэлд өртсөн нь үнэн бол эмнэлэгийн магадлагаа, албадсан нь үнэн гэдгийг нотлох агуулгыг багтаасан бичлэг хийж тавих хэрэгтэй.
- 2) Биеэ үнэлэгчийг худалдан авсан хүний мэдээллийг ч гартаа оруулж авах нь чухал бөгөөд дараа нь хуулийн дагуу арга хэмжээ авахад хэрэг болох юм.
- 3) Өдрийн тэмдэглэл, ажлын тэмдэглэл, хувийн бүртгэл зэргийг хөтөлж байх нь хэрэгтэй.
- 4) Утасаар ярьсан яриа, тухайн нөхцөл байдлыг бичлэг хийж тавьсан бол хохироогчид гэмт хэргийн үнэнийг үгүйсгэх тохиолдолд шахалт болох маш чухал нотолгоо болох юм.

6. Цагаач эмэгтэйчүүдэд илүү хэрэгтэй мэдээлэл.

- 1) Юуны өмнө солонгост бие үнэлэх үйлдлийн хохирогчдод туслах байгууллага болон зөвлөгөө өгөх төвүүд улсын хэмжээгээр бий болсон. Эрүүгийн хэрэг заргалдах гэх мэт хуулийн дагуу арга хэмжээ ава хыг хүсэхгүй тохиолдолд ч зөвлөгөө өгөх төвтэй холбогдон зөвлөгөө авч хэрэгтэй гэсэн тусламж дэмжлэгүүдийг авах хэрэгтэй. Зөвхөн гадаадын иргэнээр дагнасан бие үнэлэх үйлдлийн хохирогчдод зөвлөгөө өгөх төв одоогоор солонгост бий болоогүй байгаа бөгөөд тусламжийн байгууллага / түр оргонох байр/ түр т л ганцхан байдаг. Бүх зөвлөгөө өгөх төв болон ихэнх түр амрах байр гадаадын иргэнийг хүлээн авахгүй зөвхөн дотоодын иргэдийг хүлээн авч туслана гэсэн үг биш юм. Зөвхөн гадаадын иргэнд туслаж дэмжик байсан туршлага байхгүй учраас хэлний асуудал хамгийн том бэрхшээл болж байгаа юм. Гэсэн ч гадаадын иргэн бие үнэлэх үйлдлийн хохирогчийн хэр гийг гүйцэтгэж байгаа газар ямарч бэрхшээлгүй байгууллагууд болсон байна. Тиймээс орчуулгын төвүүдээр дамжуулан өөрсдийнхөө оршин сууж байгаа орон нутгийн зөвлөгөө өгөх төв болон тусламжийн байгууллагын танилцуул түгэ олж авах нь чухал. Дотоодын иргэнд зөвлөгөө өгөх төв болон тусламжийн байгууллагаас тусламж хүсэгчийн ойлгохгүй байгаа асуудлыг шийдэхийн тулд орчуулагчтайгаар харьцаан ямар нэгэн бэрхшээлгүйгээр туслах болно.
- 2) Олон язнын нөхцөл байдлаас болж яалт ч үгүй өөрөө биеэ үнэлэх үйлдлийг сонгосон ч гэсэн дариуухан өөр ажил олж оргон гарахыг хүсвэл ойрхон зөвлөгөө өгөх төв болон тусламжийн байгууллага гэх мэт холбогдох байгууллагыг хайн зөвлөгөө авч үзээрэй. Mash олон төрлийн үйлчилгээгээр дамжуулан өөрийнхөө сэтгэхүйн болон биеийн эрүүл мэндийг сэргээх хангалттай тусламжийг авах болно.
- 3) Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн замын хүчирхийлэл гэх мэт эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлууд дундаас ч бие үнэлэхээс сэргийлэх хуулинд т л ганцхан гадаадын иргэдийн телөө онцгой зүйл анги орсон байдаг. Мэдээж хамгийн багаар бодоход л гэхэд оршин суух ангиллын агуулга боловч бие үнэлэх үйлдлийн хохирогч гэж үзэх юм бол бүртгэлгүй ч гэсэн хэдэн удаа ч хамаагүй мэдүүлж болох бөгөөд тусламж авч болохуяаар хуулиар дэмжсэн байна.
- 4) Хуурамч гэрлэлт, хуурамч паспорт, өр зээлтэй холбоотой асуудал гэх мэт хувь хүний хууль бус үйлдэлд оролцсон нь үнэн, мөн хараат байдлаас болоод бие үнэлэх ажлаа үргэлжлүүлэн хийсээр байгаа бол нэг өдрийн өмнө ч гэсэн хурдан мэдэгдэж өөрийнхөө хохирлын үнэ нийг мэдээлэх нь бүр илүү хохирол амсахаас урьдчилан сэргийлж байгаа явдал юм. Харин ч бүр эсрэгээр хохирогч гэдэг нь тогтоогдох юм бол шийтгэл хүлээхгүйгээр хамгаалалт болон тусламж авах боломжтой гэдгийг санаж явах хэрэгтэй бөгөөд идэвхитэй арга хэмжээ авах нь чухал.

Солонгост амьдарч байгаа цагаач эмэгтэйчүүдийн заавал мэдэх ёстой зүйлс.

Тав дахь ярианы сэдэв

Онцгой нөхцөл хэзээ ч гарч бол но⁷⁾

Солонгосын нийгэмд гадаад хүн тодорхой хэмжээний байр суурь эзлэхийн тулд маш олон янзын бэрхшээл болон таагүй байдлыудтай тулгардаг. Ялангуяа санаанд ч ормооргүй зүйлүүд тохиолдох нь бий. Олон янзын мэдээллийг санах, туслапцаа авч болох байгууллагуу дыг тэмдэглэж авах нь ашигтай. Солонгосын хуулийн систем өөр учраас 'Миний бодсон хэв маяй' т шилжүүлнэ гэж бодож болохгүй. Тиймээс энгийн дагах ёстой хууль дурмийг баримтлах хэрэгтэй бөгөөд эх ороосоо солонгост орж ирэхдээ ашигласан бичиг баримтгаа хадгалих байх нь хэрэгтэй. Тэгвэл заавал санааж байх нь чухал эзэгтэй нөхцлийн талаар мэдэж авцгаая.

1. Эзэгтэй нөхцөл байдал болон гол асуудал.

Өвчин эмгэг болон осол аваар гэх мэт нь урьдчилан таамаглахын аргагүй үүсдэг. Ялангуяа улс дотор гадаад хүн гэдэг байр суурьнаас тодорхой журам ба мэдээлэл олж авах нь хэцүү байх тохиолдол их бөгөөд ашигтгүй гэж үзэж болохоор байна. Жишээлбэл: Гэрлэлтээ хэвийн үргэлжлүүлэх асуудал. Өвдөх болон тахир дутуу болох тохиолдол, авто замын осол, ажлаа хийж байгаад бэртэх тохиолдол, өвчин тусах тохиолдол, гэмт хэргийн хохирогч болох тохиолдол зэргийг тус тусад нь хуваан хариу авч болох аргуудыг хайж олох юм.

2. Эзэгтэй нөхцөл үүссэн үед хариу авах арга зам.

1) Гэр бүлийн байдаа хэвийн үргэлжлүүлэх аргагүй тохиолдол.

Солонгосын нийгэмд гадаад иргэн солонгос иргэнтэй гэр бүл болон хилээр орж ирэх тохиолдолд гэрлэлтийн цагаачлах виз авч орж ирдэг. Ийм гадаадын иргэн солонгосын иргэн гэр бүлийн хүнтэйгээ зөрчил үүссэн гэр бүлийн амьдралаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй тохиол долд гэрлэлтээ цуцлах боломжтой. Гэрлэлтээ цуцлах тохиолдолд солонгост оршин суухын тулд гэр бүл цуцлахад уг хүний хариуцлага байхгүй гэдэг нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдол, солон госын иргэншилтэй хүүхийн төрсөн эх эцэг, асран хамгаалагчаар тогтоогдсон тохиолдол, солонгосын иргэн гэр бүлийн хүн нас барсан тохиолдол гэх мэт тодорхой цөн нөхцөлд солонгост оршин суух эрхээ үргэлжлүүлэн амьдарч болно.

- ★ Гэрлэлтээ цуцласны дараа эх орондоо гэрлэлтийн асуудлаа цэгцлэх хэрэгтэй!
- Солонгост гэрлэлт цуцласан асуудал баттай болсон тохиолдолд шүүхээс холбогдогч тал тохиролцон гэр бүл цуцласан магадлгааг авах хэрэгтэй бөгөөд энэ бичгээ нотариатаар баттуулаад эх орныхоо элчин сайдын яаманд гэр бүл цуцласанг мэдүүлснээр эх орондоо ч гэр бүл цуцлалт цэгцлэгдэнэ гэдгийг санах хэрэгтэй.

7) ИЖонг А. Усан хотын цагаач эмэгтэйчүүдийн түр амрах байрны зөвлөгөч



2) Өвчин болон эрүүл мэндийн осолд өртсөн тохиолдол.

Солонгост амьдарч байгаа гадаадын иргэд ч өвдөх тохиолдол байх бөгөөд эрүүл мэндийн байгууллагаар явж байгаад эрүүл мэндийн осолд өртөх тохиолдол ч бий. Юуны өмнө өвдсон тохиолдолд эмнэлэгийн тусlamж авахын тулд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхийг шалгаарай. Гэрлэлтийн цагаач иргэдийн хувьд ажил эрхэлж байгаа гэр булийн хүний нэрээр буртгэгдсэн байдаг тохиолдол их байдаг учраас гэр булийнхнийхээ ачаар эмнэлэгт үзүүлж болох бөгөөд хөдөлмөр эрх лэгч цагаач, урт хугацааны оршин суух эрхтэй иргэдийн хувьд ажлын газар болон орон нутгийн эрүүл мэндийн даатгалд буртгүүлж болно. Эрүүл мэндийн ослын асуудал нь маш эзэртэй салбар учраас мэргэж лийн зөвлөгөө өгөх газрын тусlamжийг авах хэрэгтэй.

- * Цагаач иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадаагүй тохиолдолд ашиглаж болох эмнэлэгийн тусlamж
- Орон нутаг тус бүрийн гадаад иргэдэд яаралтай эмнэлэгийн тусlamж үзүүлэх байгууллага /орон нутаг бүрийн эмнэлэгийн ажилтан/
- Солонгосын цагаач иргэдийн эрүүл мэндийн нийгэмлэг / Эрүүл мэндийн харилцан туслах холбоо (<http://www.mumtk.org> 02-3147-0516)
- * Эрүүл мэнд ослын зөвлөгөө өгөх төв (<http://www.medioseo.or.kr/1600-4200>)


3) Сэтгэцийн өвчин болон архидан донтох гэх мэтэд авах арга хэмжээ.

Гэрлэлтийн цагаач иргэний хувьд уг хүн болон гэр булийн хүн сэтгэцийн өвчин болон архинд донтох, үр хүүхдийн оюуны хомсдол болон хөдөлгөөний дутагдалтай тахир дутуу гэх мэт асуудал үүсэх үед авах арга хэмжээ маш хэцүү. Гэвч ийм тохиолдолд эргэн тойрны болон гэр булийн хүмүүс гаднаас нь хараад шийдэж чадахгүй зүгээр өнгөрөөх ч юмуу эргэн тойрны хүмүүст хүндрэлтэй байдал үүсгэдэг учраас дайжих ч юмуу зэнд нь хаяснаас нөхцөл байдал бүр илүү хүндрэх ч тохиолдол байдал. Тиймээс тасралтгүй анхаарал тавиж ажиглах хэрэгтэй. Орон нутгийнхаа хамгийн ойрхон эрүүлийг хамгаалах газарт байрладаг сэтгэцийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан зөвлөгөө авах хэрэгтэй. Бус нутгийн сайн дурын үйл ажиллагааг ашиглан тусlamж авч болохуйц аргыг хайж үзэх хэрэгтэй.
(Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх утас 1577-0199)

4) Гэрээсээ зугатах болон сурагтай алга болох гэх мэтэд авах арга зам.

Гэрлэсэн цагаач иргэний хувьд солонгосын иргэн гэр булийн хүн ямар шалтгаанаар гэдгээ хэлэхгүйгээр гэрээсээ гараад удаан хугацаагаар холбоогүй байсан тохиолдолд хамаатан саднаар дамжуулан нөхцөл байдлыг мэдэх хэрэгтэй бөгөөд энэ нь боломжгүй бол ойрхон цагдаагийн газар очин тусlamж үүсэх хэрэгтэй. Солонгост оршин сууж бай гаа гадаадын иргэний хувьд ул мөрийг нь мэдэхийн аргагүй гэвэл сураггүй алга болсноор буртгүүлж болно. Ялангуяа эмэгтэй болон на санд хүрээгүй хүүхдийн хувьд аюулгүй байдлынх нь үүднээс гэрээ сээ гарсан хүнтэй холбоотой нотлоу баримт бичиг /иргэний үнэмлэх ний хуулбар/, гэрээсээ гарсан хүний хамгийн сүүлийн үед авахуулсан зураг, мэдүүлэгчийн биений байцаалт зэргийг авчран ойрхон цагдаагийн хэлтэс болон сэргийлэхийн эмэгтэйчүүд насанд хүрээгүйчүүдийн хэлтэс дээр очин мэдүүлнэ. Гэрээсээ зугатах үйлдэл нь тусдаа амьдарч байгааг нотлох гарцаагүй баримт учраас нухацтай хандах хэрэгтэй бөгөөд өөр шалтгаанаас болоод тусдаа амьдрах болсон гэвэл холбогдогч ойрхон цагдаагийн хэлтэс дээр очин гэрээс гарсан мэдүүлгийг цуцалж болно.

(Гэрээсээ зугатсан, сураггүй алга болсонг мэдүү лэх: Цагдан сэргийлэх газар 182 төв, сэргийлэхийн эмэгтэйчүүд хүүхдийн хэлтэс)



Солонгос гэр булийн хүн тодорхой шалтгаангүйгээр гэрээсээ гарцаад урт хугацаагаар сураггүй болболж хамаатан садангуудаас нь сураглах буюу цагдаа тывн газраас тусlamж хүснэгэй.

5) Авто ослын хохирогч болсон тохиолдолд.

Гэнэтийн авто осолд өртсөн бол цагдаад мэдэгдэх хэрэгтэй.
Эд материалын хувьд мэдүүлэх үүрэггүй боловч хохирогч гарсан тохиолдолд ослыг мэдүүлэх үүрэгтэй. Хамгийн сайн арга нь ослын газар даруй мэдүүлэх хэрэгтэй.Хэрэг болсон газар цагдаагийн ажилтан очин шалгант хийж ослын талаар нотлох баримт болохоор зураг, гэрч зэргийг баталгаажуулах нь чухал.

- * Зам тээврийн ослоос тахир дутуу болсон иргэдийн нийгэмлэг, авто тээврийн ослоос хохирогчдод зөвлөгөө өгөх төв. 02-847-1112)

6) Ажил хийж байгаад гэмтэх юмуу амь насаа алдсан тохиолдолд

Аж үйлдвэрийн осолд гэдэг нь эрхэлж байгаа ажлаасаа болоод хөдөл мөр эрхлэгч бэртэх, мэргэжлийн өвчин тусах, тахир дутуу болох мөн амь насаа алдахыг хэлнэ. Ажил хийж байгаад осол гарсан тохиолдолд яяралтай түргэн тусламжийн арга хэмжээ авсаны дараа үйлдвэрийн ослыг тогтоох эрүүл мэндийн байгууллагаруу очин эмчилгээ хийлгүү лэх хэрэгтэй. Яяралтай эмнэлэгийн тусламж авсан мэдүүлгийг бөгөөн аж үйлдвэрийн салбар, эмнэлэг, албан газартай тус тус өгөх хэрэгтэй. Хөдөлмөр хангамж халамжийн байгууллагаас ажил үүргийн явцад осолд өртсөн эсэхийг шалган 7 өдрийн дотор хөдөлмөрийн осол гэж үзэх үү, үгүй юу гэдгийг мэдэгдэнэ.

- * Компанийн эзэн гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд. Яяралтай эмнэлэгийн тусламж авсан анкетанд осолд өртөгчийн биеийн байдал, ослын гэрч, ослын тохиолдолыг тэмдэглэн осолд өртөг болон ажиллуулж байсан газрын эзний гарын үсэг байх хэрэгтэй боловч компанийн эзэн гарын үсэг зурахаас татгалзах юм бол шалтгааныг тодорхой бичиж өгч болно.
- * Хариуцсан ажлын агуулга болон ослын нөхцөл гэх мэтийн талаар хир үнэн бодитой эсэхийг тодруулах хэрэгтэй гэсэн тохиолдолд асуудлыг шийдэх хугацаа хойшлогдож болох юм.
- * Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв:
<http://www.kcomwel.or.kr> 1588-0075

7) Гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд

Хэн ч гэмт хэргийн хохирогч болох боломжтой. Гэмт хэргээс үүдсэн хохирол гэдэг нь зөвхөн шууд хохиролыг хэлэх ч биш маш олон янзын сэтгэл санааны, бие эрхтэний, эдийн засгийн зэрэг шаналалд өртө хийг хэлнэ. Гэмт хэргийн хохиролд өртөгч, түүний гэр бүлийнхэн зөвлөгөөгөөр дамжуулан маш олон төрлийн тусламжийн агуулгатай та нилцан хууль зүй, эрүүл мэнд, эдийн засгийн тусламж авч болно. Ялангуяа гэмт хэргийн хохирогчид ойр зуурын хэргэцээний менгэ, нас барсан иргэний үр хүүхдэд сургалтын тэтгэлэг, зайлшгүй хэрэгтэй бүтээгдэхүүн гэх зэрэгээр ч бас туслаж байна.

- * Солонгосын гэмт хэргийн хохирогчдод туслах нэгдсэн төв
<http://www.kcvc.net> 1577-1295

3. Гол тусlamж үзүүлдэг байгууллагууд болон харилцах утас

기관명	전화번호	비고
Цагаач эмэгтэйчүүдэд яаралтай тусlamж үзүүлэх төв	1577-1366	Цагаач эмэгтэйчүүдэд хүчирхийлийн зөвлөгөө
Танүри кул төв	1577-5432	Олон соёлт амьдралын зөвлөгөө
Эмэгтэйчүүдийн шуурхай утас	1366	Гэр булийн хүчирхийлийн зөвлөгөө
Хүүхдийн хүчирхийлийг мэдэгдэх	1577-1391	Гэр булийн доторхи хүүхдээ тарчлаах, сургуулийн хүчирхийлэл гэх ээргийг мэдээлэх
Өндөр настанг хамгаалах төв мэргэжлийн байгууллага	1577-1389	Настайчудийг тарчлаасан талаар мэдээлэх
Сургууль, эмэгтэйчүүдийн хүчирхийлэл болон бие үнэлэх үйлдлийн хохирогч наарт яаралтай туслах төв	117	Бие үнэлэх гэмт хэрэг, сургуулийн хүчирхийлэл, гэр булийн хүчирхийлэл гэх мэтийг мэдээлэх
Гэмт хэргийн мэдээлэл	112	Бүх төрлийн гэмт хэргийг мэдээлэх
Интернатийн донтонд туслах төв	1599-0075	Интернатийн донтоны зөвлөгөө
Сэтгэцийн эрүүл мэндийн хямралд зөвлөгөө өгөх утас	1577-0199	Амна хорлоогоос урьдчилан сэргийлэх, сэтгэцийн хямралын зөвлөгөө
Дасан кул төв	120 (+)9	Сөүлийн зөвлөгөө /гадаад иргэнд орчуулагчай зөвлөгөө өгөх боломжтой
Гадаад иргэдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн лавлагaa	1345	Оршин суух, визний зөвлөгөө
Солонгосын ёсвер насныханы зөвлөгөө	1388	Өсвер үеийнхэнд утасаар зөвлөгөө өгөх
Сургуулийн хүчирхийлэл SOS тусlamжийн байгууллага	1588-9128	Сургуулийн хүчирхийлийн зөвлөгөө
Хүүхэд асрагч	1577-2514	Эрүүл мэнд гэр бүл тусlamжийн төв/ хүүхэд асрах
Эрүүл мэнд, эмчилгээ мэдээллийн төв	1339	Яаралтай эмчилгээ / эмнэлэгийн мэдээлэл
Солонгосын амь насны утас	1588-9191	Амна хорлоогоос урьдчилан сэргийлэх, сэтгэцийн хямралын зөвлөгөө
Эрүүлийг хамгаалах, нийгэм хalamжийн дуудлагын утас	129	Эрүүлийг хамгаалах, нийгэм хalamжийн яамны зөвлөгөө
Улсын хүний эрхийн зөвлөл	1331	Хүний эрхийн зөвлөгөө
Мөнгө санхүүгийн хяналтын зөвлөгөө	1332	Мөнгө санхүүгийн зөвлөгөө
Засгийн газрын нэгдсэн өргөдөл, хүсэлт хүлээн авах үйлчилгээний дуудлага төв	110	Засгийн газрын нэгдсэн өргөдөл, хүсэлт хүлээн авах үйлчилгээ
Солонгосын интернатийн зөвлөгөө	118	Хувийн мэдээлэлд халдсан талаар зөвлөгөө
Хөдөлмөрийн яам	1350	Хөдөлмөрийн хууль журам, тогтолцооны зөвлөгөө
Улсын тэтгэврийн цогцолбор	1355	Улсын тэтгэврийн зөвлөгөө
Алга болсон хүүхдийг хайх төв	182	Төөрсөн хүүхэд, гэрээсээ зугтсан мэдүүлэг
Хэрэглэгчийн зөвлөгөө өгөх төв	1372	Амьдралын хэрэглээний талаар
Гадаадын жуулчдад туслах төв	1330	Гадаадын жуулчдад танилцуулга



이주여성을 위한 위기대응 노트

이주여성이 한국생활에서 꼭 알아야 하는 것들

후원_  여성가족부



서울시 종로구 송인동 168-78 전화_ (02)3672-8988 전송_ (02) 3672-8990 홈페이지_ www.wmigrant.org